



**ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2022 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/185

Улаанбаатар хот

Тушаал хүчингүй болгох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Иргэний нисэхийн үндэсний төвийн зохион байгуулалтын бүтэц шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр үзлэг, гурван шатны хяналтыг зохион байгуулах журам батлах тухай" 2019 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн А/688 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.

2.Дээрх журмыг Иргэний нисэхийн үндэсний төвийн зохион байгуулалтын бүтэцтэй уялдуулан шинэчлэн баталж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын үүргийг хавсран гүйцэтгэгч (Н.Батсайхан)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газрын дарга (Т.Батжаргал)-т даалгасугай.

ДАРГА



С.МӨНХНАСАН